



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 4/192

Хархорин сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшүүлэх дуудлага худалдаанд өндөр үнэ хэлж ялагч болсон ИР98111833 регистрийн дугаартай Бат-Эрдэнийн Тэмүүлэнд Эрдэнэтолгой багийн нутаг дэвсгэр Усжуулах 1-1а тоотод байрлалтай 5600м<sup>2</sup> газрыг худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолборын зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Захирамжийг үндэслэн Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 11.6 дахь заалтын дагуу газар эзэмшихтэй холбогдсон зураг төслийг 6 сарын дотор багтаан боловсруулж батлуулсны дараа газар эзэмшлийн гэрээ байгуулж, гэрчилгээ олгож, улсын бүртгэлд бүртгэж, тэмдэглүүлж, хүлээлтэн өгөхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт зөвшөөрсүгэй.

3. Газрын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг иргэн (Б.Тэмүүлэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ОДГЭРЭЛ

401100383